

Мөрийн хөтөлбөрийн оронд

Бүрэлдэхүүн сургуулийн захирал нь МУИС-ийн эрхэм зорилго, зорилтод хүрэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд ажиллаж удирдах зөвлөл, эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөл зэрэг хамтын удирдлагын шийдвэрээр үйл ажиллагаагаа явуулдаг билээ. Ийм учраас захиралд нэр дэвшигч миний бие нь тусгайлан мөрийн хөтөлбөр боловсруулж түүндээ ийм аугаа сайхан зүйлийг хийж, сургуулийн ирээдүйг тийм гоё сайхан болгоно гэх мэтээр бичихийн оронд ямар зарчмыг баримтлан, юуг эрхэмлэн, ямар үйл ажиллагааг илүүтэй дэмжин ажиллах талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлэн бичлээ.

МУИС-ийн эрхэм зорилгыг “Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн болон технологийн салбарт шинэ мэдлэг бүтээж, түгээн дэлгэрүүлдэг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний их сургууль байж, улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулна”, ХШУИС-ийн эрхэм зорилгыг “Шинжлэх ухааныг техникийн болон нийгмийн өргөн олон салбарт хэрэглэх мэдлэг оюуны үндсэн цөм, тэргүүлэгч байж техник, технологи ба нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаанчаар шийдвэрлэх, нийгэмдээ үйлчлэх, улс орны хөгжилд дорвитой хувь нэмрээ оруулах, иргэний өндөр ухамсар, соёлтой шилдэг мэргэжилтнүүдийг бэлтгэх.” хэмээн тодорхойлсон билээ.

Дээрхи зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах ерөнхий зарчмуудыг баримтлан ажиллана:

- Монгол улс, МУИС, ХШУИС-ийн нийтлэг эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах
- Энэ зорилгод нийцсэн аливаа сайн үйл бүхнийг дэмжих
- МУИС-ийн дээд удирдлага болон ХШУИС-ийн хамт олныг холбох гүүр болон ажиллах
- Багаар буюу хамтаар ажиллах зарчмыг баримталж, хүлээсэн үүргээ биелүүлэхийн төлөө ажиллахын зэрэгцээ хууль эрх зүйн хүрээнд шийдвэр гаргаж, шаардлагатай үед аливаа асуудлыг хамт олны оролцоотойгоор шийдвэрлэж байх
- Бидний хоёр дахь гэр орон болсон сургууль маань нийтэч, хамтач халуун дотно хамт олон бүхий орчин байхын төлөө ажиллах
- Багш, ажилчдынхаа эрүүл ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх
- Багш, ажилчдынхаа мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Хууль, дүрэм журмын дагуу шаардлага тавьж, шаардлагатай үед хариуцлага тооцож чаддаг байх
- Цаг үеийн онцгой нөхцөл байдалд нийцүүлэн сургуулийн анги танхим, орчны эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэхийн төлөө ажиллах

Онцгойлон анхаарч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Бидний ажил дээрээ өдөр бүрийн хамгийн их цагаа зарцуулан хийж байдаг хоёр чиглэлийн үйл ажиллагаа байдаг. Нэг нь сургалт буюу шинжлэх ухааны мэдлэгийг хүнд өгөх буюу өвлүүлэх, нөгөөх нь судалгаа шинжилгээний ажил буюу шинэ мэдлэгийг бүтээх явдал юм. Энэхүү үйл ажиллагаагаар бид манлайлагч байхын төлөө буюу тодруулбал ХШУИС нь сургалт, судалгаа, эрдэм шинжилгээгээрээ ч төдийгүй, хүний нөөц, материаллаг баазаараа ч МУИС-даа тэргүүлэгч байхын төлөө ажиллана.

Манай сургуулийн сургалтын хөтөлбөр, мэргэжлийн чиглэлүүд, цахим техник технологийн хурдацтай хөгжил, титэмт вирүсийн цар тахлын нөхцөл байдал зэргийг харгалзан удирдлагын түвшинд дараах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Цахим сургалт, түүний дэд бүтцийг хөгжүүлэх:

Шинэ үеийн оюутнуудын цахим техникт илүү ойр өссөн сэтгэл зүйн онцлог болон цар тахал тархаж буй цаг үетэй холбоотойгоор бүх багш хичээлээ танилцуулах веб хуудастай, дуутай видео лекцтэй, шалгалтаа цахим хэлбэрээр авдаг/авах асуулт тестийн сантай болох, үүнд зориулсан дэд бүтцийг хөгжүүлэхэд онцгой анхаарах

- Ирээдүйн инженерүүдийг бэлтгэж буй сургалтын лабораториудыг сайжруулах

Азийн шилдэг сургуулиудын түвшинд ойртох зорилго тавиад ажиллаж буй их сургуулийн хувьд инженерчлэлийн хөтөлбөрүүдийн сургалтын лабораториуд ядаж л тэдгээрээс хол хоцрогдоогүй байх хэрэгтэйг тайлбарлах шаардлагагүй бөгөөд лабораториудаа шинэчлэхэд онцгой анхаарах болно.

- Мэдээллийн технологийг ХШУИС-даа өргөнөөр нэвтрүүлэх

ХШУИС-ийн онцлог байдлыг дагаад хүний хүч хөдөлмөрийг хэмнэж, тэр хэмнэсэн цаг хүчээ өөр ашигтай зүйлд зориулах боломжийг олгодог, нөөц бололцоог илрүүлэн гаргаж өгдөг гэх мэтээр олон давуу талыг олгодог мэдээллийн технологийг дээр дурьдсанаар зөвхөн сургалтанд төдийгүй хүний нөөц, удирдлага, санхүү, хөтөлбөрийн хороо, эрдэм шинжилгээнд гээд өргөн хүрээнд нэвтрүүлэхэд онцгой анхаарах болно

- Ойрын үед хэрэгжүүлэх боломжтой, МУИС-ийн нийт үйл ажиллагаанд ач тустай:

ХШУИС-д юм уу, МУИС-д зөвхөн нэг ажил, санаачлагыг чинь хэрэгжүүлбэ гэвэл сүүлийн жилүүдэд МУИС-ийн удирдлагуудад үргэлж дэвшүүлэн ярьж тайлбарлан байдаг нэг саналаа хэлэх болно. Энэ нь маш энгийн зүйл буюу оюутнуудын судлах хичээлийнх нь саналыг нэг улирлаар бус, төгсөх хүртэлх бүх улирлын хувьд авах явдал юм. Бид чухамдаа оюутны төлбөрөөр санхүүждэг төдийгүй, бидний ажил тэдний судлан буй хичээлүүдээс хамаарч байгаа тул судлах хичээлийн саналыг нь төгсөх хүртэлх хугацааных нь хувьд улирал бүрээр авчихвал бид ойрын 2-оос 3 жилийн сургалтын ажлаа, хичээлийн хуваариа, багшийн ачааллаа, багшийн орон тоо болон хичээлийн анги танхимийн хэрэгцээгээ гээд олон зүйлийг төлөвлөж чадахын зэрэгцээ оюутнууд ч 1, 2 жилийн дараа тэдэн сарын тэдэнд, хэдэн цаг минутад ямар хичээл үзээд сууж байхаа хүртэл төлөвлөсөн байна. Улмаар оюутныг зөвхөн голч дүнгээр бус энэхүү төлөвлөгөөгөө биелүүлж чадаж байгаагаар нь үнэлэхэд ч ашиглах боломжтой ба урсгалаараа сурч ажилладаг бус, хариуцлагатай, ухамсартай сэхээтэн болоход ч тус нэмэртэй юм.

Та бүхнийг хүндэтгэсэн

МУИС, ХШУИС:

Док. Д.Бямбажав

Улаанбаатар. 2020-11-01